



СУХБААТАР АЙМАГ ДАХЬ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

2024 ОНЫ З ДУГААР УЛИРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 09 дугаар сарын 25

Баруун-Урт сум

Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Сүхбаатар аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 4 орон тоотой ажиллахаар батлагдсан бөгөөд 3 орон тоотойгоор ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2024 онд хийх ажлын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г ЭМДЕГ-ийн дарга, аймгийн Засаг даргатай байгууллаа. Хэлтсийн 2 мэргэжилтэн хэлтсийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгууллаа.



Зураг 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгууллаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын хууль, Эрүүл мэндийн сайдын тушаал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал, ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтийг хэлтсийн албан хаагчид ханганд ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, эрүүл мэндийн даатгалын төлөлт, ЭМДЕГазрын цахимд хуудсанд оруулсан мэдээллийг байгууллагын цахим хуудас болон, орон нутгийн цахим 18 хаягт пост 186, рийл 53, цахим контент 108-ийг шинээр бэлдэж мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилан ажилласан.



Хэлтсийн 2 өрөөнд гэрээт үйлчлэгчээр өдөр тутам цэвэрлэгээг тогтмол хийлгэж байна. Мөн сард 1 удаа их цэвэрлэгээг 3 албан хаагч хийж байна.



Зураг 2. Цэвэрлэгээг тогтмол хийж байна

Хоёр. Тесев, санхүүгийн чиглэлээр:



Зураг 3. Интернетийн хурдыг шийдвэрлэсэн

2024 оны эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төсвийн батлагдсан хувиараар нийт 8,312,262.1 мянган төгрөг бүрдүүлэхээр тусгагдсан. Үүнээс:

№	Ажил олгогч даатгуулагчын төлөх шимтгэл		Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагсдын шимтгэл	
1	Tөлөвлөгөө	Орлого	Tөлөвлөгөө	Орлого
2	7,575,012.8	4,140,600.0	737,249.2	427,442.4

2024 онд хамтран ажиллах 42 эрүүл мэндийн байгууллагатай гэрээлэн ажиллаж байна. Үүнд:

1. АНЭ-1
2. УАУНЭ-1
3. Хувийн эмнэлэг-3
4. СЭМТ-12
5. ӨЭМТ-2
6. Эмийн сан-23



**Эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор
тооцсон санхүүжилт /01-08 сар/**

№	Эмнэлгийн нэр	Нэхэмжлэл /мян төг/	Хасагдал /мян төг/	Олгосон дүн /мян төг/
1	АНЭ	11183698.6	853628.7	10330069.9
2	Төр хариуцах эм	21255.2	0	21255.2
3	Эрт илрүүлэг	208950.0	15715.0	193235.0
4	Хувийн эмнэлэг	655794.6	91997.7	563796.8
5	Уламжлалтын нэгдсэн эмнэлэг	545530.4	46431.8	499098.5
6	Сумын ЭМТ	335870.2	49407.0	286463.2
7	Өрхийн ЭМТ	172791.0	6998.5	165792.5
8	Эмийн сан	1174371.6	12775.5	1161596.1
9	ӨЭМТ анхан шатны санхүүжилт	950464.5		950464.5
10	СЭМТ анхан шатны санхүүжилт	6219942.8		6219942.8
	Нийт	24114096.0	1317887.2	22796208.8

Эрүүл мэндийн байгууллагуудад шилжсэн санхүүжилтийг олгохоор тооцсон дүнг санхүүгийн програмтай сар бүр тулган өглөг авлагыг хянан ажиллаж байна.

Эрүүл мэндийн сангийн зарлагын төсвийн гүйцэтгэл, ирүүлсэн нэхэмжлэлд хяналт тавьж, сар бүр хүргүүлсэн.

Гурав. Тогтоол шийдвэрийн биелэлтийн талаар:

Монгол улсын 5 хууль, УИХ-ын 5 тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, ЭМСайдын албан даалгавар, ЭМДЕГ-ийн даргын тушаалын хэрэгжилтийг хангаж, Эрүүл мэндийн даатгалын салбарт мөрдөж байгаа бусад хууль дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын хуулийн санал 1 удаа, ЭМДҮЗ-ийн 6,8,12 дугаар тогтоолын шинэчлэлд 3 удаа, сэтгэл ханамжийн судалгааны төсөлд санал хүргүүлсэн. Гэрээт эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, шүдний эмчийн тусгай зөвшөөрөл болон магадлан итгэмжлэлийн судалгааг Мэдээлэл технологийн хэлтэс, Худалдан авалт гэрээлэлтийн газарт тус бүр гаргаж хүргүүлсэн.

ЭМДҮЗ-н тогтоол, ерөнхий газрын даргын тушаал, журам, бусад хууль тогтоомжийн дагуу Эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэлийн хяналтыг сар бүр хийж санхүү хэлтэст 79 гүйцэтгэлийн нэхэмжлэл, тайланг үнэн зөв гарган хүргүүлсэн.

Долоо хоног бүрийн 2 дахь өдрийн шуурхай хурлын дараа хэлтсийн хурлыг хийж мэргэжилтэнүүдэд 7 хоногт хийх ажил үүргийн хуваарь гарган биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Манай байгууллагад нийт 27 өргөдөл, 164 албан хүсэлт ирснийг тухай бур нь шийдвэрлэлээ. Үүнд:

- Иргэнээс ирсэн 27 өргөдөл
- Цагдаагийн газраас 119 албан хүсэлт



- Прокурорын газраас 2 албан хүсэлт
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 3 албан хүсэлт
- Иргэдэд утсаар болон, биеэр ирж үйлчилгээ авсан 553 иргэнд хурч үйлчилсэн
- Төр хариуцах 43 иргэн, овог нэр, хаяг засварлах 5 иргэний мэдээллийг health.gov.mn програмд оруулсан.

Нэгж	Ирсэн албан бичиг	Явсан албан бичиг	Санал хүсэлт	Өргөдөл гомдол	Ирсэн дотоод албан бичиг	Явсан дотоод албан бичиг
Тоо	127	182	0	27	37	16
Шийдвэрлэлтийн хувь	100%	100%		100%	100%	100%

Удирдлагаас өгсөн хугацаатай судалгаа болон цаг үеийн асуудлыг тухай бүр биелүүлж ажиллаж байна.

Чиглэл	Үүрэг даалгавар	Хэрэгжилтийн хувь
Шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгавар	17	100
Тушаалаар өгөгдсөн, үүрэг, даалгавар	4	100
Газрын даргын зөвлөлийн хурлаар өгөгдсөн үүрэг, даалгавар	0	

Дөрөв. Дотоодын хяналт шалгалтын чиглэлээр:

Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын тусlamж үйлчилгээний чанар, хүртээмж, гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавин ажиллаж, даатгуулагчийн эрх ашгийг дээдлэн, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, даатгалын байгууллагын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагад үзүүлсэн тусlamж үйлчилгээний нэхэмжлэх, албан тоот, анхан шатны баримт материалыг 100 хувь цахимаар авч хэвшээд байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын тусlamж үйлчилгээ үзүүлсэн нэхэмжлэл, албан тоотын хамт дараа сарын 01-ээс 05-ны дотор цахимаар [/sua-invoice@emd.gov.mn/](mailto:sua-invoice@emd.gov.mn/), [\(\[health.gov.mn\]\(http://health.gov.mn\)\)](http://health.gov.mn) програмтай тулган хүлээн авч байна. 01-08 дугаар сард 616 нэхэмжлэлийг хүлээн авч хяналтыг хийсэн. Нэхэмжлэх зөрүүтэй ирүүлсэн 13 нэхэмжлэлийн зөрчлийг арилгуулж хүлээн авсан.



Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэхээр ЭМДҮЗ-н тогтооцууд, эмнэл зүйн удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу 19 гэрээт эрүүл мэндийн байгууллагын анхан шатны баримтыг хянан шалгаж эмнэл зүйн шалгуураар хянан 485.4 сая төгрөгний зөрчлийг илрүүлэн санхүүжилтийг бууруулж шилжүүлсэн. Сар бүрийн нэхэмжлэлийн хяналтын дараа Эрүүл мэндийн байгууллагуудад улсын байцаагчийн 65 зөвлөмжийг хүргүүлсэн.

Гэрээт 43 эрүүл мэндийн байгууллагатай 2024 оны хагас жилээр тооцоо нийлэн баталгаажуулан санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Гэрээт 19 эрүүл мэндийн байгууллагуудын 01-08 дугаар сарын нэхэмжлэлийн хяналтыг ЭМДҮЗ-н тогтооцууд, шалгуураар хянаж хасагдал, зөрчлийг сар бүр албан бичгээр хүргүүлж, улсын байцаагчийн 65 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

1 of 2

СҮХБААТАР АЙМАГИЙН НЕВНОЦСАН
СҮМЫН ОРГҮҮЛ МЭНДИЙН ТӨВИН
ДААТГАЛЫН ЦЭЛЭНГЭ ТАНАА

Энэхүү түүрээс иштээвэл суралтадаар 2023 оны 13 дугаар сарын 08ны өдөр болсон Эрүүл мэндийн байгууллагын шатны баримтыг хянан шалгаж эмнэл зүйн шалгуураар хянан 485.4 сая төгрөгний зөрчлийг илрүүлэн санхүүжилтийг бууруулж шилжүүлсэн. Сар бүрийн нэхэмжлэлийн хяналтын дараа Эрүүл мэндийн байгууллагуудад улсын байцаагчийн 65 зөвлөмжийг хүргүүлсэн.

Дээр зөвлөмжийг бодижуулж эшшижүүлж төхөнчдөй тундуулж 10-10 дугаар сарын 08-ны 10-12 дахь төвийнэдээгүй дээрээс куулжүүлж иштээвэл суралтадаар

ДЭЛГЭНЭР АЛДААНЫ
ДААТГАЛЫН
ЧЛЮКИЛТЫА

ОРГҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЧЛЮКИЛТЫА БААНДАЧА

М.АЗААНА

ХУЛГАН АЛСАН
СҮХБААТАР АЙМАГИЙН МОНХААН
СҮМЫН ОРГҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИН ЦЭЛЭНГЭ

С.СОЛОНГА

1711137803

Эмийн сангийн 2023 оны гэрээг дүгнэн 2 эмийн санд зөвлөмж, 2 эмийн сангийн гэрээг цуцалсан. СЭМТ-өөс 4 сумын ЭМТөвд зөвлөмж хүргүүлсэн.

Новартис эм борлуулах гэрээ байгуулсан эмийн сангудын татан авалт, нөөцэд тулгалт хийж эмийн танилцуулга мэдээллийг иргэд, даатгуулагчдад тайлбарлаж, таниулах, эмийг үйлчлүүлэгчийн нүдэнд ил харагдахуйц байршуулах, гэрээний хэрэгжиллийг хангаж ажиллахыг мэдэгдлээ.



Зураг 4. Гэрээт эмийн сангудад новартис эмийн татан авалт, нөөцэд хяналт хийлээ



ЭМДҮЗ-ийн 12-р тогтоолын шалгуур үзүүлэлтийн дагуу түүвэрлэгдсэн нэхэмжлэлийг Эрүүл мэндийн байгууллагуудруу цахимаар илгээж 15636 түүврийг хугацаанд хүлээн авч хянасан.

2024 онд гэрээтэй 23 эмийн сангийн хөнгөлөлттэй эм худалдан авсан нэхэмжлэлийг сар бүр хянан эмийн сангудад цахим жор бичих эрхтэй эмч нарын судалгааг авч мэдээлэл технолгийн хэлтэст хүргүүлсэн. Нийт 23 эмийн санд 35561 хүний 1161.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Сүхбаатар сумын гэрээт 2 эмийн санд дараах зөрчил дутагдал гарсныг илрүүлж худалдан авалт гэрээлэлтийн газарт дотоод албан бичгээр мэдэгдсэн. Сүхбаатар сумын Эрүүл мэндийн төвийн эмч нар нь Манду фарм, Пэлжир фарм эмийн сангийн эрхлэгч наарт болон иргэнд сар бүр өндөр үнэ бүхий хөнгөлөлттэй эмийн жор бичиж даатгуулагчдад бодит үзлэг хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн. Хэлтсийн Улсын байцаагчийн албан шаардлагыг 2 эмийн сан, Сүхбаатар сумын эрүүл мэндийн төвд хүргүүллээ.

Гэрээт эрүүл мэндийн 43 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг тулгаж байгууллагын нэр зөрүүтэй хэвлэгдсэн 2 гэрчилгээг Эрүүл мэндийн газрын тусгай зөвшөөрлийн комисст хүсэлт гарган зөрчлийг арилгууллаа.

Байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор үйлчилгээний талаар хэлтсийн пэйсбүүк хаягаар Сэтгэл ханамжийн судалгааг QR код уншуулахаар байршуулан цахимаар авч байна. Цахим судалгаанд 185 иргэн хамрагдаад байна.

Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Тус онд төрийн байгууллагаас лавлагаа авах 124 баримт, дотоод албан бичиг 37, зохион байгуулалтын 3 албан бичиг ирүүлсэнг цахим мэдээллийн санг бүрдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 115 албан тоот холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.



Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 2023 оны 18 ширхэг баримтыг стандартын дагуу архивласан.

Зураг 5. Архивласан баримтууд

Гэрээт эрүүл мэндийн байгууллагын хувийн хэргийг баяжуулж, санхүүгийн баримт бичгийг хавтаслан хаягжуулж, өдөр тутмын албан бичгийн хавтасыг Монгол бичгээр хаягжуулсан.



Зургаа. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/89 дугаар тушаалаар 1 албан хаагч зэрэг дэв ахисан. Зэрэг дэвийн нэмэгдлийг 3 албан хаагч авч байна. Төрийн жинхэнэ 3 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ <https://meduuleg.iaac.mn/>-д хугацаанд нь мэдүүлж, хувийн хэргээ баяжуулсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 3 албан хаагч хагас жилээр гарган дүгнэж явуулсан. 2024 оны бүтээмжийн урамшуулалт, үр дүнгийн урамшууллыг 3 албан хаагч авсан. Орон нутгийн нэмэгдэл 10 хувийн урамшууллыг 4 дүгээр сараас авч байна.

Хэлтсийн албан хаагчдыг ажиллах таатай нөхцөл байдлаар хангаж ЭМДЕГ-аас шинээр 2ш сандал, 1ш жижиг шүүгээ, дэлгэц 2ш өгсөн. Мөн улирал бүр бичиг хэрэг, цэвэрлэгээний бараа материал ирүүлж байна.

Байгууллагын ажилтан албан хаагчдын ажлын цагийн бүтээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/192 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг мөрдөн ажиллаж байна. Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтыг Able цахим программд бүртгүүлж, сар бурийн 05, 20-ны өдрүүдэд цагийн бүртгэлийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлж байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын 3 хүүхдэд ЭМДЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн тус бүр 100.0 мянган төгрөгний бэлгийн карт, дурсгалын зүйлийг гардуулж өгсөн.



Зураг 6. Албан хаагчдын хүүхдүүдээ бэлэг гардууллаа

Долоо. Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох” хөтөлбөрт тусгаснаар дараах сургалтуудад хамрагдсан. Үүнд:

Албан хаагчдын сургалтад хамрагдсан байдал		
Сургалт зохион байгуулсан газар (ЭМДЕГ-аас бусад)	Сургалтын сэдэв	Оролцсон албан хаагийн тоо
1. Төрийн албаны зөвлөл	Пүрэв гариг бурийн цахим сургалт	3



2. Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын систем "DocX" ашиглах цахим сургалт	2
3. Төрийн бус байгууллага	Лхагва гариг бүрийн "Мэдээллийн цаг" цахим сургалт	3
4. Аймгийн засаг даргын тамгын газар	Нийгмийн даатгалын тухай багц төслийг танилцуулах, санал авах	3
5. Аймгийн архивын тасаг	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан түүнийг дагаж гарч буй журам, дүрмийг таниулах	1
6. Төрийн албаны зөвлөл	Төрийн албаны ёс зүй	2
7. Аймгийн засаг даргын тамгын газар	Нээлттэй цахим эрүүл мэнд	2
8. Аймгийн засаг даргын тамгын газар	"Төрийн бүтээмжийн сэргэлт – Цахим эрүүл мэнд"	3
Нэгжээс зохион байгуулсан сургалт		
Сургалтын сэдэв	Оролцогчид	Хамрагдсан оролцогчдын тоо
1. Нэхэмжлэлийн хяналтаар, Үндсэний зөвлөлийн тогтоолуудаар	СЭМТ, ӨЭМТ, Лавлагaa шатлалын эмнэлэгүүд, эмийн сангийн, хувийн эмнэлэгийн дарга нарт	41
2. ЭМДҮЗ-ийн 8 дугаар тогтоол шинэчлэх хэлэлцүүлэг	СЭМТ, ӨЭМТ, Лавлагaa шатлалын эмнэлэгүүд, хувийн эмнэлэгийн дарга нарт	19
2. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, Ебаримтаар даатгалаа хялбар төлөх заавар	Иргэд, үйлчлүүлэгчдэд	1652
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл, ач холбогдол	Албан байгууллага, ААНэгжийн ажилчдад	168
4. Цахим системд бүртгэл мэдээллийн хөтлөлтийн байдал	СЭМТ, ӨЭМТ, Лавлагaa шатлалын эмнэлэгүүд, хувийн эмнэлэгийн дарга	19
5. Өвчний түүхийг цахим програмд шивж оруулах	СЭМТ, ӨЭМТ, Лавлагaa шатлалын эмнэлэгүүд, эмийн сангийн, хувийн эмнэлэгийн дарга нарт	40
6. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол	5 дугаар цэцэрлэгийн багш ажилчид	15
7. ЭМДҮЗ-ийн 5,6-р тогтоол гарч буй алдаа дутагдал	УАУНЭ, хувийн эмнэлэг-ийн албан хаагчид	25
8. ЭМДҮЗ-ийн 5,6-р тогтоол гарч буй алдаа дутагдал	АНЭ-ийн яаралтай тусламжийн албан хаагчид	12
9. ЭМДҮЗ-ийн 2023 оны "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах" 8 дугаар тогтоол болон 2023 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 6 дугаар тогтоол	Гэрээт ЭМБ-ийн дарга нар	48
10. ЭМДҮЗ-ийн 6-р тогтоол	Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эрчимт эмчилгээний тасаг	6



Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, зааварын талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн пэйж хуудас болон фэйсбууک хаягаар тухай бүр хэлтсийн албан хаагчид аймгийн хамгийн их дагагчтай 18 цахим хаягт байршуулж, ЭМДЕГ-аас оруулсан мэдээллийг өдөр бүр 3 албан хаагч шэйрлэж, лайк дарсан. Иргэдэд утсаар болон биечлэн мэдээллийг өгч ажилласан. Нийт давхардсан тоогоор 5609 хүнд мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгаа өгч ажиллалаа. Үүнд:

- ЭМБ-ын албан хаагчдад танхимаар өгсөн сургалтанд-313
- Цахим сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо-210
- Иргэдэд өгсөн сургалт, мэдээлэл-1652
- Албан газарт мэдээлэл өгсөн тоо-44
- Утсаар болон биеэр ирсэн иргэдэд мэдээлэл өгсөн иргэдийн тоо-3390
- Цахим хуудсаар мэдээ, мэдээлэл авсан иргэдийн тоо-8240
- Гарын авлага, тараах материалыг байршуулсан албан байгууллагын тоо-43
- Орон нутгийн ТҮ-д өгсөн мэдээллийн тоо 1

Эрүүл мэндийн даатгалын хууль, эрүүл мэндийн тухай хууль, ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоолууд, Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтээр гэрээт АНЭ, эмийн сан, АНЭ, Уламжлалтын нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд 2 удаагын сургалтанд давхардсан тоогоор 313 албан хаагчид хамрагдсан.



Зураг 7. Гэрээт эрүүл байгууллагын албан хаагчдад сургалт өглөө

Монгол улсын засгийн газрын 2024 оны 321 дүгээр тогтоол "Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ", Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн салбар, нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан, Эрүүл мэндийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгөөр Эрүүл мэндийн даатгалаар иргэдэд мэдээлэл өгч, гарын авлага өгч ажиллалаа.

Баруун-Урт сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй "НАЙРСАГ БАРУУН-УРТ ТЕАТР" нээлттэй хаалганы өдөрлөгт Эрүүл мэндийн даатгалтай холбоотой тусlamж үйлчилгээг хэрхэн авах, ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээ, хялбар төлөх зааварчилгаа, иргэд, албан байгууллагын албан хаагчдад Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгтээ заавал хамрагдаж хэвших мэдээллийг өгч гарын авлага төрсөн орчинд.



Зураг 8. Нээлттэй хаалганы өдөрлөг

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн З албан хаагч ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт /турээслэгч, үсчин, жолооч/ ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдэд /малчин, оюутан/ эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчилж, мэдээллээр ханганд, даатгалд хамруулах үйл ажиллагааг аймгийн төвийн З том худалдааны төв, үйлчилгээний байгууллага эмийн сан, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлэг, лавлагaa шатлалын эмнэлэгүүдтэй хамтарч нийт 3390 иргэнд мэдээлэл өглөө. Үүнээс 475 иргэний төлөлтийг газар дээр нь шалгаж, 125 иргэн төлөлтөө ебаримтаар төлсөн.

Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор ЭМДЕГ-аас ирүүлсэн сургалт сурталчилгааны тараах материал, гарын авлагыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд мэдээллэл хүргэн ажилласан.




Зураг 9. Аймгийн төвийн худалдааны төв, хувийн хэвшлийн байгууллагад мэдээлэл өглөө



Зураг 10. Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч ажиллалаа

Найм. Онцлох ажил:


Хэлтсийн цахим Facebook групп хуудсыг нээн шинэ мэдээллийг тогтмол оруулж иргэдэд хүргэж байна. Facebook хаяг 465 хүнээр, пэйж хуудас 355 хүнээр нэмэгдэж хандалт 4110, 186 удаа шэйр хийсэн. Байгууллагын пэйсбүүк хуудсанд ажлын өдөр 1-ээс доошгүй контентийг бэлтгэн оруулж байна.



Зураг 11. Цахим хаягийг өдөр бүр ажиллуулж байна



Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газраас санаачилсан “Хамтдаа даван туулъя” малчдад туслах аянд Сүхбаатар аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн хамт олон 200.0 мян төгрөг хандивлаж аянд нэгдлээ.



|Зураг 12. “Хамтдаа даван туулъя” аянд нэгдлээ

Ес. Дүгнэлт

Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусlamж, үйлчилгээг худалдан авахад анхаарч, эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусlamж үйлчилгээнд нэхэжлэлийн хяналтыг журмын дагуу хийж хэрэгжүүлж, эрүүл мэндийн даатгалыг үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлсэнээр эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт өсөж, даатгуулагчдад үзүүлэх тусlamж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байгаа нь бидний ололт амжилтын нэг юм.

2024 оны гэрээт эрүүл мэндийн байгууллагийн сар бурийн гүйцэтгэлийн санхүүжилт хугацаандаа шилжихгүй байгаа нь хүндэрэл учруулж байна.

Цаашид хийх ажлууд:

- Орлого хамралтын чиглэлээр:**
Малчин иргэний орлого, хамрагдалтыг нэмэгдүүлэхэд төлөвлөгөө боловсруулан ажиллах
- Сургалт сурталчилгааны чиглэлээр:**
Хэлтсийн цахим хаягуудын хандалт, хүний тоог сайжруулна.
- Хяналт шалгалтын чиглэлээр :**
Нэхэмжлэлийн хяналтыг сайжруулж ажиллахаас гадна төлөвлөгөөт хяналтыг нэмэгдүүлнэ.
- Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр :**
Аймгийн иргэдийн хуралд 2024 оны ажлаа танилцуулах, иргэдийг мэдээ мэдээлэлээр хангахаар орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- Архив бичиг хэргийн стандартт сайжруулах чиглэлээр:**
Албан тоотыг хос бичгээр үйлдэхэд суралцана.
- Тайлан, судалгааны чиглэлээр:**



Арав. Санал:

1. Эрүүл мэндийн даатгалын шинэ ажил, үйлчилгээ нэвтрүүлсэн гадаад, дотоодын /орон нутаг, дүүргийн хэлтэс/ үйл ажиллагаатай танилцан, туршлага судлах
2. Орлого бүрдүүлэлтэнд малчин иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах
3. Эрүүл мэндийн даатгал төлөлт хамрагдалтыг онлайнаар аймаг, сумаар сар бүрээр хүний тоо, мөнгөн дүнгээр хардаг болох.
4. 2020 оны хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй НР-2010 принтер доголдсон тул принтерийг шинэчлэх шаардлагатай байна. Гурван үйлдэлт G3010 өнгөт принтер хар өнгөөр хэвлэхэд принтерийн бул эвдэрсэн тул засварлуулах шаардлагатай.
5. Хэлтсийн даргын шинээр тохижуулсан нэг өрөөнд хувцасны шүүгээ, цэвэр усны баллон, суурь нэн даруй шаардлагатай байна.
6. Одоогоор 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа тул Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн /эмч/ шаардлагатай тул төрийн албаны зөвлөлд хүсэлт хүргүүлж, ажлын байрыг зарлуулах хүсэлтэй байна.
7. Гэрээт эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтийг сар бүр тогтмол шилжүүлэх

ТАЙЛАН БИЧСЭН:

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Ч. ТАМИРАА